



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 08 өдөр

дугаар 1/73

Улаанбаатар хот

Г

Г

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулийн 26¹ дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын байцаагчийн мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны жил бурийн төсөвт тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

151201497

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2022 оны 04 дугаар сарын 08-ны өдрийн
73 дугаар тушаалын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙЦААГЧИД МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙГ ТОГТООХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгохтой холбогдон үүсэх харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Мэргэшлийн зэрэг нь нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа улсын байцаагч (ахлах)-ийн эрхтэй байцаагч (цаашид "улсын байцаагч" гэх)-д хамаарна.

Хоёр. Мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт

2.1. Тэрүүлэх мэргэшлийн зэргийг улсын байцаагчийн шалгалтад 2 ба түүнээс дээш удаа тэнцсэн доор дурдсан шалгуур хангасан улсын байцаагчид олгоно. Үүнд:

2.1.1. нийгмийн даатгалын байгууллагад 8-аас доошгүй жил ажилласан байх;

2.1.2. төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр сүүлийн 1 жилийн хугацаанд "А буюу маш сайн", "В буюу Сайн" үнэлгээтэй дүгнүүлсэн байх;

2.1.3. сүүлийн 1 жил ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

2.2. Зөвлөх мэргэшлийн зэргийг доор дурдсан шалгуур хангасан улсын байцаагчид олгоно. Үүнд:

2.2.1. энэ дүрмийн 2.1-д заасан мэргэшлийн хүчинтэй зэрэгтэй байх;

2.2.2. нийгмийн даатгалын байгууллагад 12-оос доошгүй жил ажилласан байх;

2.2.3. төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр сүүлийн 2 жилийн хугацаанд "А буюу маш сайн", "В буюу Сайн" үнэлгээтэй дүгнүүлсэн байх;

2.2.4. сүүлийн 2 жил ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

2.3. Итгэмжит зөвлөх мэргэшлийн зэргийг доор дурдсан шалгуур хангасан улсын байцаагчид олгоно. Үүнд:

2.3.1. энэ дүрмийн 2.2-т заасан мэргэшлийн хүчинтэй зэрэгтэй байх;

2.3.2. нийгмийн даатгалын байгууллагад 18-аас доошгүй жил ажилласан байх;

2.3.3. төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг сүүлийн 3 жилийн хугацаанд "А буюу маш сайн", "В буюу Сайн" үнэлгээтэй дүгнүүлсэн байх;

2.3.4. сүүлийн 3 жил ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

Гурав.Мэргэшлийн зэрэг тогтоох, түдгэлзүүлэх

3.1.Аймаг /нийслэл/, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/ нь улсын байцаагчид мэргэшлийн зэрэг тогтоолгох саналыг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ируулэх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.1.1.энэ дүрмийн 2.1-2.3-т заасан шалгуур хангасныг нотлох баримт бичиг;

3.1.2.энэ дүрмийн 3.1.1-д заасан нотлох баримт бичгийг үндэслэн хамт олны хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэр.

3.2.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэргэшлийн зэрэг тогтоолгох улсын байцаагчийн баримт бичгийг шалгаж нэгтгэн, саналыг Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

3.3.Мэргэшлийн зэргийг тогтоох асуудлыг Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор шийдвэрлэнэ.

3.4.Мэргэшлийн зэргийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ. Үүнд:

3.4.1.албан хаагч төрийн албанаас түр чөлөөлөгдсөн бол ажилдаа эргэн орох хүртэл;

3.4.2.хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацаанд.

3.5.Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад шилжин эсхүл сэлгэн ажиллах хугацаанд тухайн улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг хэвээр хадгалагдана.

3.6.Улсын байцаагч нь төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан, нас барсан, ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргасан нь нотлогдож сахилгын шийтгэл хүлээсэн бол мэргэшлийн зэргийг тухай бүр хүчингүй болгоно.

3.7.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэргэшлийн зэргийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай саналыг тухай бүр нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

Дөрөв.Зэргийн нэмэгдэл олгох

4.1.Энэ дүрмийн 2.1-2.3-т заасан шалгуур хангасан улсын байцаагчид шат дараалан мэргэшлийн зэргийг олгоно. Мэргэшлийн зэргийг шат дараалан олгох доод хугацаа 1 жил байна.

4.2.Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийгмийн даатгалын байгууллагад улсын байцаагчийн эрхтэйгээр төрийн жинхэнэ албан хаагчаар ажиллаж байгаа хугацаанд олгоно.

Тав.Бусад зүйл

5.1.Энэ дүрмийг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.